

БҮРТГЭВ

БҮРТГЭВ № 11
ХАН УУЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗАР
ТАМГЫН ГАЗАР

БАТЛАВ
ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ
ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ

Г.НЯМДАВАА

БАТЛАВ
МОНГОЛЫН ГЭЗЭВЭР, ХОЛБОО, ГАЗРЫН
ТОСНЫ ҮЙЛДВЭРЧНИЙ ЭВЛЭЛҮҮДИЙН
ХОЛБООНЫ ДАРГА
Б.РАГЦАА

ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР, ТҮҮНИЙ ХАРЬЯА
БАЙГУУЛЛАГУУДАД 2016-2017 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ
ХАМТЫН ГЭРЭЭ

2016 оны 8 дугаар
сарын 18 ны өдөр

Улаанбаатар хот

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Монгол Улсын нэгдэн орсон Олон Улсын гэрээ конвенци, Хөдөлмөрийн тухай хууль, Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулиудыг үндэслэн Нэг талаас Иргэний нисэхийн ерөнхий газрын захиргаа /цаашид ажил олгогч гэх/, нийт ажилтныг төлөөлж ИНЕГ-ын ҮЭ-ийн хороодын төлөөлөл /цаашид ажилтны төлөөлөгч, хамтад нь талууд гэх/ харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

1.2. Гэрээний хугацаа дуусахад шинээр гэрээ байгуулаагүй, нэмэлт өөрчлөлт оруулаагүй бол дараагийн гэрээг байгуулагдах хүртэлх хугацаанд энэхүү гэрээ хүчин төгөлдөр мөрдөгдөнө.

1.3. Талууд хамтын гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай саналаа нөгөө талд бичгээр гаргаж, тухайн үед хэлэлцэн нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

1.4. Талууд гэрээнд заасан аливаа асуудалд тэгш эрхтэй оролцоно.

1.5. Гэрээний хэрэгжилтийн талаар улирал тутам нийт ажилтанд мэдээлэл хийж, гэрээний хоёр талын эрх ашигтай холбоотой асуудал, хууль тогтоомжийг танилцуулах, цаг үеийн ажилтай холбогдолтой сэдвээр мэдээлэл хийх зорилгоор мэдээллийн цагийг хамтран ашиглана.

1.6. Ажилтны төлөөлөгч хамтын гэрээ, хэлэлцээрийн заалтыг биелүүлэх талаар шаардлага тавьж хөдөлмөрийн хамтын маргаан үүсгэх эрхийг эдэлнэ.

1.7. Ажил олгогчийн харьяалал, удирдлагын бүтэц, бүрэлдэхүүн өөрчлөгдөх нь хамтын гэрээг цуцлах үндэслэл болохгүй бөгөөд хэрэгжилтийг хангах үүргийг гэрээний талууд үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

1.8. Хамтын гэрээнд талуудын төлөөлөгчид гарын үсэг зурсан өдрөөс хойш ажлын 10 хоногийн дотор эрх бүхий байгууллагад бүртгүүлэх харьяа байгуулага, алба, орон нутгийн нисэх буудлуудад хүргүүлэх, сурталчлах үүргийг гэрээний талууд хамтран хэрэгжүүлнэ.

1.9. Талууд хамтын гэрээг байгуулахдаа цаашид улам бүр сайжруулан боловсронгуй болгох зарчмыг баримтлана.

2016 оны 08 сарын 23